

БАТЛАВ:
ЗАВХАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА
Г.ӨНӨРБАЯР

СОЁЛЫН ЗОРИУЛАЛТААР ИДЛЭГ ШОНХОР ШУВУУ БАРИУЛАХ ГЭРЭЭ

2024 оны 07 дугаар
сарын 08-ны өдөр

Дугаар 2024/01

Завхан аймаг

А талаас Завхан аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Пүрэвдорж (цаашид "Аймаг" гэх), Б талаас Арабын Нэгдсэн Эмират Улсын Ерөнхийлөгч Эрхэмсэг дээд ноён Н.Н. Sheikh Mohammed Bin Zayed Al Nahyan (цаашид "Бэлэг хүлээн авагч" гэх) түүнийг төлөөлөн, итгэмжлэгдсэн төлөөлөгч Ibrahim Husini Husien (паспортын дугаар 013658191 хамтад нь ("Талууд" гэх), нар Завхан аймгийн нутаг дэвсгэрээс Идлэг шонхор шувууг соёлын зориулалтаар барих эрхийг олгох харилцааг зохицуулах, талуудын эдлэх эрх, хүлээх үүргийг тодорхойлох зорилгоор энэхүү гэрээг байгуулав.

НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү гэрээний зорилго нь соёлын зориулалтаар идлэг шонхор шувууг Завхан аймгийн нутаг дэвсгэрээс барих, түүнд хяналт тавихтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын 2024 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн ТГ/399 дугаартай албан бичгийн хавсралтад тусгагдсан соёлын зориулалтаар бариулах идлэг шонхорын хуваарийн дэс дугаараар тус гэрээний дугаарыг олгоно.

ХОЁР. АЙМГИЙН ХҮЛЭЭХ ЭРХ, ҮҮРЭГ

- 2.1. 2024 онд 20 (хорь) хүртэлх тооны идлэг шонхор шувуу барих зөвшөөрлийг бэлэг хүлээн авагч талд олгож, тэдгээрийн төлөөлөгчдийг 2024 онд идлэг шонхор шувуу барихад нь туслалцаа үзүүлэх, энэ талаар холбогдох сумдын захиргаа, байгаль орчны алба, цагдаа болон бусад байгууллагуудад албан ёсоор мэдэгдэнэ.
- 2.2. Бэлэг хүлээн авагч талд бэлэглэж буй идлэг шонхор шувууны төлбөр, хураамжийн гүйцэтгэлд хяналт тавьж ажиллана.
- 2.3. Идлэг шонхор шувууг орон нутгаас бариулахдаа Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас олгосон тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллагын судлаач ажилтнуудын заавар зөвлөмжийн дагуу хамтран ажиллаж хяналт тавина.
- 2.5. Соёлын зориулалтаар бэлэглэсэн идлэг шонхор шувууг барих, гадаад улсад гаргах үйл ажиллагааг явуулах зтгээд нь Монгол Улсын хууль тогтоомжийг зөрчих, идлэг шонхор барих үйл ажиллагааны талаар зураг, бичлэгийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн цахим хуудаст байршуулах, орон нутагт ёс бус үйл ажиллагааг явуулсан тохиолдолд энэхүү гэрээ болон зөвшөөрлийг хүчингүй болгоно.

ГУРАВ. БЭЛЭГ ХҮЛЭЭН АВАГЧ ТАЛЫН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ

- 3.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт идлэг шонхор шувуу барих Арабын Нэгдсэн Эмират улс руу тээвэрлэх ажлыг Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн, өөрийн зардлаар зохион байгуулна.

3.2. Гэрээнд заагдсан нутаг дэвсгэрээс идлэг шонхор шувууг барих бөгөөд гэрээнд заагдаагүй газраас болон олгосон зөвшөөрөлд заасан тооноос илүү идлэг шонхор шувуу барихыг хориглоно.

3.3. Монгол Улсын хууль, тогтоомж, үндэсний ёс заншлыг хүндэтгэн, орон нутгийн ЗДТГ болон иргэдийн зүгээс тавьж байгаа аливаа хууль ёсны шаардлагыг биелүүлж ажиллана.

3.4. Нэг идлэг шонхор барихдаа 3-аас илүүгүй шувуу (хөхвөр тагтаа, монгол ногтруу)-г өгөөш болгон, ашиглаж, насны хувьд тухайн жилийн залуу шувууг хүйсийн (эр/эм) харьцаа тэнцүү байхаар барина.

3.5. Тусгай хамгаалалттай газар нутгаас идлэг шонхор шувууг барихыг хориглох бөгөөд энэхүү зарумыг үйл ажиллагаандаа хатуу мөрдөж ажиллана.

3.6. Тусгай зориулалтаар тагтаа, ногтруу зэрэг амьтдыг агнахдаа зөвшөөрсөн тоо хэмжээнээс илүү гаргаж агнахгүй, шархдуулж гэмтээхгүй ажиллана.

3.7. Нас болон хүйсийн хувьд барих ёсгүй, шаардлага хангаагүй идлэг шонхор шувуу барьсан тохиолдолд далавч болон сүүлний залуур өдийг гэмтээхгүйгээр буцаан суллаж тавина.

3.8. Байгалийн нөөц ашигласны төлбөрийг тус амьтны экологи, эдийн засгийн үнэлгээний 80 хувиар, хураамжийг Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.35-д заасны дагуу 5 хувиар тооцож зохих дансанд шилжүүлнэ.

3.9. Идлэг шонхор шувуу барих отог бүрд англи хэлний орчуулагчийг заавал ажиллуулах, тухайн отог тухайн сумын нутгаас гарахын өмнө хэдэн тооны шонхор, ямар нас, хүйсийн (эр, эм) бодгалийг авч гарах гэж байгаа талаар мэдээллийг аймаг, сумын байгаль орчны газрын мэргэжилтэнд мэдэгдэж мэдээллийг бүрэн өгнө.

3.10. Судалгааны зориулалтаар бөгжилсөн, бичил дамжуулагч суулгасан, радио телеметрийн долгион дамжуулагч тавьсан идлэг шонхор шувуу барихгүй байх, өвчилсөн, гэмтсэн шувууд болон өөр зүйлийн махчин шувууд урхинд орсон баригдсан тохиолдолд буцаан тавьж, холбогдох мэдээллийг Байгаль орчин, аялал жуулчлалын газарт өгч ажиллана.

ДӨРӨВ. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

4.1. Гэрээнд талууд гарын үсэг зурж, тамга дарснаар гэрээ хүчинтэй болно.

4.2. Энэхүү гэрээ нь 2024 оны 07 дугаар сарын 08-ны өдрөөс 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийг дуустал хүчинтэй байна.

ТАВ. БУСАД ЗҮЙЛ

5.1. Идлэг шонхор барих үйл ажиллагаанд ажиллах тээврийн хэрэгслийн марк, дугаар, эзэмшигчийн мэдээллийг гэрээний хавсралтаар батлах бөгөөд тусгайлсан наалт тэмдгийг тээврийн хэрэгсэл тус бүрийн урд талын хаалганд харагдахуйц байдлаар нааж байрлуулна.

5.2. Энэхүү гэрээний 6.1-т заасан наалт, тэмдэггүй тээврийн хэрэгслийг идлэг шонхор шувуу барих үйл ажиллагаанд ашиглахгүй, аль болох тогтсон маршрутаар явах бөгөөд олон тооны машин тэргээр сүлжилдэн явж бэлчээр болон газрын хөрс талхлахаас сэргийлэх.

5.3. Барьсан идлэг шонхор шувууны хөлд тухайн аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газраас олгосон зүүлтийг зүүж, арчлан тээвэрлэж, гадаад улсад гаргах үйл ажиллагааг явуулна. Зүүлтгүй идлэг шонхор шувууг хууль бусаар агнаж, барьсанд тооцно.

3.2. Гэрээнд заагдсан нутаг дэвсгэрээс идлэг шонхор шувууг барих бөгөөд гэрээнд заагдаагүй газраас болон олгосон зөвшөөрөлд заасан тооноос илүү идлэг шонхор шувуу барихыг хориглоно.

3.3. Монгол Улсын хууль, тогтоомж, үндэсний ёс заншлыг хүндэтгэн, орон нутгийн ЗДТГ болон иргэдийн зүгээс тавьж байгаа аливаа хууль ёсны шаардлагыг биелүүлж ажиллана.

3.4. Нэг идлэг шонхор барихдаа 3-аас илүүгүй шувуу (хөхвөр тагтаа, монгол ногтруу)-г өгөөш болгон, ашиглаж, насны хувьд тухайн жилийн залуу шувууг хүйсийн (эр/эм) харьцаа тэнцүү байхаар барина.

3.5. Тусгай хамгаалалттай газар нутгаас идлэг шонхор шувууг барихыг хориглох бөгөөд энэхүү зарумыг үйл ажиллагаандаа хатуу мөрдөж ажиллана.

3.6. Тусгай зориулалтаар тагтаа, ногтруу зэрэг амьтдыг агнахдаа зөвшөөрсөн тоо хэмжээнээс илүү гаргаж агнахгүй, шархдуулж гэмтээхгүй ажиллана.

3.7. Нас болон хүйсийн хувьд барих ёсгүй, шаардлага хангаагүй идлэг шонхор шувуу барьсан тохиолдолд далавч болон сүүлний залуур өдийг гэмтээхгүйгээр буцаан суллаж тавина.

3.8. Байгалийн нөөц ашигласны төлбөрийг тус амьтны экологи, эдийн засгийн үнэлгээний 80 хувиар, хураамжийг Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.35-д заасны дагуу 5 хувиар тооцож зохих дансанд шилжүүлнэ.

3.9. Идлэг шонхор шувуу барих отог бүрд англи хэлний орчуулагчийг заавал ажиллуулах, тухайн отог тухайн сумын нутгаас гарахын өмнө хэдэн тооны шонхор, ямар нас, хүйсийн (эр, эм) бодгалийг авч гарах гэж байгаа талаар мэдээллийг аймаг, сумын байгаль орчны газрын мэргэжилтэнд мэдэгдэж мэдээллийг бүрэн өгнө.

3.10. Судалгааны зориулалтаар бөгжилсөн, бичил дамжуулагч суулгасан, радио телеметрийн долгион дамжуулагч тавьсан идлэг шонхор шувуу барихгүй байх, өвчилсөн, гэмтсэн шувууд болон өөр зүйлийн махчин шувууд урхинд орсон баригдсан тохиолдолд буцаан тавьж, холбогдох мэдээллийг Байгаль орчин, аялал жуулчлалын газарт өгч ажиллана.

ДӨРӨВ. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

4.1. Гэрээнд талууд гарын үсэг зурж, тамга дарснаар гэрээ хүчинтэй болно.

4.2. Энэхүү гэрээ нь 2024 оны 07 дугаар сарын 08-ны өдрөөс 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийг дуустал хүчинтэй байна.

ТАВ. БУСАД ЗҮЙЛ


5.1. Идлэг шонхор барих үйл ажиллагаанд ажиллах тээврийн хэрэгслийн марк, дугаар, эзэмшигчийн мэдээллийг гэрээний хавсралтаар батлах бөгөөд тусгайлсан наалт тэмдгийг тээврийн хэрэгсэл тус бүрийн урд талын хаалганд харагдахуйц байдлаар нааж байрлуулна.

5.2. Энэхүү гэрээний 6.1-т заасан наалт, тэмдэггүй тээврийн хэрэгслийг идлэг шонхор шувуу барих үйл ажиллагаанд ашиглахгүй, аль болох тогтсон маршрутаар явах бөгөөд олон тооны машин тэргээр сүлжилдэн явж бэлчээр болон газрын хөрс талхлахаас сэргийлэх.

5.3. Барьсан идлэг шонхор шувууны хөлд тухайн аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газраас олгосон зүүлтийг зүүж, арчлан тээвэрлэж, гадаад улсад гаргах үйл ажиллагааг явуулна. Зүүлтгүй идлэг шонхор шувууг хууль бусаар агнаж, барьсанд тооцно.

2024/01 тоот гэрээний 1 хавсралт

ИДЛЭГ ШОНХОР БАРИХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД
ОРОЛЦОХ ИРГЭДИЙН ЖАГСААЛТ



№	ОВОГ НЭР	ИРГЭНШИЛ	ПАСПОРТЫН ДУГААР
1	IBRAHIM HUSINI	SYR	N013658191
2	NASER BATHAN SULTAN QARAN ALMANSOORI	ARE	GZLJ29643
3	DEMIRI MUHAMMED	TURK	U26306950
4	DEMIRI MUHAMMET	TURK	U22642758
5	DEMIRI JAVAL	TURK	U26307048
6	БАТЖАРГАЛ ОЧИР	MGL	ШБ87031371

ИДЛЭГ ШОНХОР БАРИХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД
АШИГЛАГДАХ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ЖАГСААЛТ

№	МАШИНЫ ДУГААР	МАРК
1	88-06 YEX	LEXUS
2	77-57 УНМ	LEXUS
3	01-05 УАУ	LAND CRUISER
4	18-09 УНХ	LAND CRUISER
5	87-07 УБИ	PRUIS